



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

“Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2019 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Ч.Золбаяртай байгуулсан 2019 оны контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Ч.Золбаяртай байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА

3.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000236